



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/191

Арвайхээр сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хавсралтын 1.4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын ерөнхий боловсролын “Тэмүүлэл-Эрдэм” сургуулийн багш нарын Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Шилийн гол аймгийн Ажил мэргэжлийн дээд сургуульд айлчлан, туршлага солилцож, мэргэжил дээшлүүлэх сургалтын зардлыг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Тус 3,144,600 (гурван сая нэг зуун дөчин дөрвөн мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0396

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 13 -ны өдрийн 1191 дугаар
захирамжийн хавсралт



ТУРШЛАГА СОЛИЛЦОЖ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ
СУРГАЛТЫН ЗАРДАЛ

№	ШААРДАГДАХ ЗАРДАЛ	НЭГ БҮР	ТОО ШИРХЭГ	НИЙТ
1.	Өвөрхангай аймгаас Улаанбаатар, Улаанбаатараас Өвөрхангай аймаг явах зардал	44,600	3*2=6	267,600
2.	Улаанбаатар хотоос Замын- Үүд, Замын-Үүдээс Улаанбаатар хот явах зардал	97,000	3*2=6	582,000
3.	Замын-Үүдээс Эрээн хот, Эрээн хотоос Замын-Үүд явах зардал	30,000	3*2=6	180,000
4.	Эрээн хотоос Шилийн гол аймаг, Шилийн гол аймгаас Эрээн хот явах зардал	90,000	3*2=6	540,000
5.	Сургалтын зардал	175,000	3*3=9	1,575,000
Нийт зардал				3,144,600

-оОо-